



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 298

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг  
шинэчлэн тогтоож, балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 158,013,054.47 (нэг зуун тавин найман сая арван гурван мянга тавин дөрвөн төгрөг дөчин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 80,000,000.00 (наян сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Тогтоолын хавсралтад заасан төрийн өмчит байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ

132005609  
17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны ... дугаар сарын ... өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ  
 СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНУУДЫН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	Ниссан патрул, улсын дугаар ХОУ 00-47	2012/2013	71,723,412.00	Ховд аймгийн мал эмнэлгийн газарт	30,000,000.00	4
2	Ниссан патрул, улсын дугаар ӨМУ 52-38	2007/2007	54,809,645.20	Дундговь аймгийн мал эмнэлгийн газарт	25,000,000.00	4
3	Ниссан патрул, улсын дугаар ЗАН 80-94	2012/2013	31,479,997.27	Дархан-Уул аймгийн мал эмнэлгийн газарт	25,000,000.00	4
	Нийт дүн		158,013,054.47 (нэг зуун тавин найман сая арван гурван мянга тавин дөрвөн төгрөг дөчин долоон мөнгө)		80,000,000.00 (наян сая)	